



БАГА БОЛОВСРОЛЫН ТЕХНОЛОГИ ХИЧЭЭЛИЙГ БУСАД ХИЧЭЭЛТЭЙ ИНТЕГРАЦЧИЛАХ НЬ

Б.Жаргал^а
^аМУБИС-Багшийн сургууль

Холбоо барих зохиогч: Jargal.b@msue.edu.mn 

Хүлээн авсан: 2024.08.25

Хянагдсан: 2024.09.20

Зөвшөөрсөн: 2024.10.25

Хураангуй

Бидний судалгаа нь бага боловсролын сургалтын хөтөлбөр дэх хичээлийн агуулга, ачааллын асуудалд онцгойлон анхаарч, хичээлүүдийн уялдаа холбоо, интеграцчилал дутмаг байгаа ба зайлшгүй шийдвэрлэх шаардлагатай зөрчил бэрхшээлүүд байна гэж онцолсон.

Асуудлыг шийдвэрлэх боломжийн нэг хувилбар нь технологийн хичээлийг бусад хичээлтэй агуулгаар нь интеграцчилах гэж үзсэн. Ингэснээр хичээлүүдийн агуулга арга зүйд шууд эерэг холбоо хамааралтай гэсэн таамаглал дэвшүүлсэн юм.

Бид онолын болон чанарын судалгааны аргуудыг ашиглан бага боловсролын хөтөлбөрийн нэгээс тавдугаар ангийн бүх хичээлийн агуулгыг харьцуулан судалсан. Судалгааны үр дүнд агуулгаараа холбогдсон хичээлүүдийг гадаад интеграци талаас нь сургалтыг явуулах буюу технологи хичээлийг математик, хүн орчин, хүн байгаль, дүрслэх урлаг хичээлүүдтэй уялдуулан боловсролын салбар хоорондын үүднээс авч үзэх боломжтойг бидний судалгаа харуулсан.

Технологийн хичээлийг бусад хичээлүүдтэй нэгтгэх нь хэд хэдэн давуу талтай байна. Тухайлбал, агуулгын хэмжээг багасгах, сургалтын ачааллыг бууруулах, уламжлалт арга барилаас татгалзах, сургалтын технологид тулгарч буй бэрхшээлийг шийдвэрлэх юм.

Эцсийн дүндээ энэхүү нэгдсэн арга барил нь хичээлийн чанарт, орохгүйгээр орхигдуулж байгаа технологийн хичээлийн агуулгад, хүүхдийн ерөнхий хөгжилд эерэгээр нөлөөлнө гэж үзсэн.

Түлхүүр үг

Ачаалал, агуулга, боломж, сургалтын чанар, хүүхдийн хөгжил

Удиртгал

Эрдэмтэн судлаач доктор, дэд профессор Д. Дашхүү “Дүрслэх урлагийн боловсролын стандарт, сургалтын хөтөлбөр, сурах бичиг, тэдгээрийн уялдаа холбоог шинэчлэх асуудалд” сэдэвт судалгаандаа (МУБИС-ДУТС, 2013, х.87): БСШУ яамны сайдын 2010 оны 201 тоот тушаалаар 1, 2, 3-р ангиудын дүрслэх урлагийн хичээлийг технологитой нэгтгэж Дүрслэх урлаг, Технологийн хичээл нэртэйгээр 56, 64, 68 цагаар заах болгосон. Ийм өөрчлөлт хийсэн ч заадаг багш нар нь бага ангийн багш хэвээр байгаа. Бодит амьдрал дээр тэдний мэргэжлийн зэрэглэл, цалин хөлс, ажлын үр дүнг ангийнх нь хүүхдүүдийн зөвхөн монгол хэл тооны хичээлийн чанараар үнэлдэг тул тэд дүрслэх урлаг, технологийн хичээлийг заахаасаа илүү, түүний цаг дээр тоо бодлого давтах, унших, цээж бичиг хийлгэдэг нь олон жилийн турш хэвшил болсон. Энэ асуудал нь бага боловсролын багш нарын мэргэжил дээшлүүлэх модуль сургалтын үеэр тэднээс авсан судалгаа, хийсэн ярилцлагаас болон өдөр тутмын хичээл сургалтын явцад хийсэн ажиглалтаас тодорхой харагдаж байгаа юм гэжээ. Мөн МУБИС, Багшийн сургуулийн технологи дидактикийн багш нарын хийсэн “Бага боловсролын сургалтанд дүрслэх урлаг, технологийн хичээлийн эзлэх байр суурь” сэдэвт судалгаанд (МУБИС-ДУТС, 2013, х.203): Дүрслэх урлаг технологийн хичээлийг хуваарьт цагийн дагуу ордог уу? Гэсэн асуулгад 88 хувь нь хуваарийн дагуу ордог, 3 хувь нь заримдаа өөр хичээл оронд нь ордог, 9 хувь нь гол хичээл биш тул ордоггүй, улсын шалгалтгүй гэсэн шалтгаанаар огт ордоггүй гэж хариулсан байгаагаас хархад дээрх 12 хувь үзүүлэлтээр сурагчид хохирч байгаа нь энэ асуудлыг авч үзэх болсон шалтгаан юм.

БШУЯ-ны сайд Л.Энх-Амгалан: Боловсролын хүрээлэнгээс нийт 1-12 дугаар ангийн хөтөлбөр, сурах бичгүүдэд үнэлгээ хийсэн. Энэ үнэлгээгээр бусад оронтой харьцуулахад манай улсын хөтөлбөрийн агуулга хүнд, хичээлүүдийн тоо нь их байна гэсэн ийм дүгнэлт гарсан. Үүн дээр үндэслээд бид агуулгаа эргэж харах, ялангуяа бага ангийн сурагчдын ачааллыг бууруулах хамгийн зөв арга нь хичээл хоорондын сургалтын агуулгын интеграцыг нэгтгэх асуудал юм. Чанартай боловсрол хөтөлбөрийн агуулгатай л уялдана (zarig.mn, 2022): гэж нэгэн ярилцлагадаа хэлсэн нь энэ сэдвийг судлах хэрэгцээ шаардлага байна гэсэн санаа юм.

Ялангуяа технологийн хичээлийн агуулгыг бусад хичээлүүдтэй уялдуулсан тохиолдолд хичээлийн агуулга нь заах арга зүйтэй шууд холбоо хамааралтай юм гэсэн таамаглал дэвшүүлж байна.

Үндсэн хэсэг

Интеграци гэдэг ойлголтыг шинжлэх ухаануудын хооронд байх ойлголт талаас нь Б.М.Кедров, И.Т.Фролов, М.Г.Чепиков нар судалсан (Интеграция науки.М, 1975) бол интеграци бол салшгүй нэгдмэл нэг бүхэл бүтэн зүйл бий болгох явц, түүний үр дүн юм гэж Оросын эрдэмтэн И.Д.Зверев үзсэн.

В.И.Максимова, Г.И.Беленький, А.В.Усова, М.Н.Скаткин, И.Я.Лернер нар хичээл хоорондын холбоо нь 3 түвшинд хэрэгжих тухай үзэл санааг дэвшүүлсэн. Үүнд:

- 1-р түвшин бол агуулга- мэдээллийн түвшний хичээл хоорондын холбоо,
- 2-р түвшин бол үйлдэл- үйл ажиллагааны түвшний хичээл хоорондын холбоо,

- 3-р түвшин бол зохион байгуулалт- арга зүйн түвшний хичээл хоорондын холбоо гэж ангилсан байна.

Хичээл хоорондын агуулгын уялдаа нь сургалтын ерөнхий зорилго, агуулга, арга, хэлбэр, хэрэглэгдэхүүнээр тодорхойлогддог бөгөөд боловсрол олгох, сурган хүмүүжүүлэх, хөгжүүлэх үүргээр зангидагдана.

Боловсролын агуулгын интеграцчиллын үндсэн үүргүүдийг эрдэмтэн В.Н.Берулава дараах төрлүүдэд авч үзсэн байна. Боловсролын агуулгын интеграцчиллын үүргүүд нь бүхэлдээ сургалтын явцын сургах, хүмүүжүүлэх, хөгжүүлэх үүргээр дамжин хэрэгждэг (Берулава, 1993, с.99) гэжээ. Интеграцийн үүрэг: арга зүйн үүрэг, мэргэшлийн чиглэлийн үүрэг, тогтолцооны үүрэг, бүхэллэг байх үүрэг, политехникийн чиглэлийн үүрэг, асуудал дэвшүүлэх үүрэг. Эдгээр үүргүүд нь бидний судалгааны арга зүйн нэг хэлбэр болж байгаа юм.

Сургалтын хөтөлбөрийн интеграци -Curriculum integration-Интеграция образовательной программы- Нэгдмэл, цогц сургалтыг дэмжих үүднээс сургалтын агуулгыг нэгтгэж, уялдуулах үйл явц (ДЭЭД БОЛОВСРОЛЫН нэр томъёоны монгол-англи-орос тайлбар толь, 2019, х.154) гэж тайлбарласан байдаг.

Сургалтын агуулгыг интеграцчилах арга замын тухай Ичинхорлоо.Ш (2013) Сургалтын онол хэрэглээ номондоо: Шинжлэх ухаан, техник технологийн мэдээлэл асар их хурдацтай өсч байгаа өнөө үед бид сургалтыг уламжлалт байдлаар үргэлжлүүлэн явуулаад байх нь агуулгын хэмжээг улам их болгож, ЕБС-ийн сурагчдын сурах ачааллыг улам бүр нэмэгдүүлж байна. Хүрээлэн байгаа байгаль, нийгмийн орчны тухай мэдлэг боловсрол эзэмшүүлэх, сурагчдыг бие хүн болгон төлөвшүүлэхийн тулд нийгмийн болон байгалийн ухаан, математик, урлаг уран сайхны үйл ажиллагааны чиглэлийн бүлэг хичээлүүдийн холбоог сайжруулах шаардлагын үүднээс сургалтын агуулгыг интеграцчилах үзэл санаа урган гарсан гэж үзсэн. Энэ үзэл санааны гол үндэс нь хүүхдэд хүрээлэн буй байгаль, нийгэм ба хүний тухай нэгдмэл төсөөлөл, үзэл төлөвшүүлэх явдал бөгөөд энэ нь гүн ухаан, эдийн засаг, нийгэм, улс төрийн олон талын ач холбогдолтой гэж үзсэн.

Агуулгын интеграцыг дотоод, гадаад гэж хоёр ангилна. Дотоод интеграци нь: Сэдэв доторх нэгж ухагдахуун хооронд, сэдэв хооронд, бүлэг сэдэв хооронд, тухайн салбар хооронд, анги ба боловсролын шатлал хооронд байдаг. Гадаад интеграци нь: Шинжлэх ухаан ба хичээл хооронд хийгддэг. Бид судалгаагаа гадаад интеграци талаас нь хийсэн.

Хичээл хоорондын холбоо хамаарлыг агуулгаар нь интеграцчилахдаа мэдлэгийн түвшинд, үйлийн арга барилын түвшинд гэсэн байдлаар интеграци хийх ба мэдлэгийн түвшний интеграци- уялдаа холбоотой хоёр ба түүнээс дээш хэд хэдэн хичээлүүдийн агуулгад байдаг адил төстэй тулгуур хууль, ойлголт, онол, баримт сэлт, зарчим дүрэм, туршлагын мэдлэг, ухагдахуун зүй тогтол, үзэл, аргын холбоо хамаарал юм. Үйлийн арга барилын түвшний интеграци- суралцагчдын ур чадвар, бичих, унших, зурах, хэмжих, тооцоолох, угсрах, чимэглэхтэй холбоотой. Бид судалгаагаа хийхдээ бага боловсролын 1-5р ангийн хичээлүүдийн агуулгыг технологи хичээлийн агуулгатай холбоо хамаарлаар нь интеграци байх талаас нь мэдлэгийн болон үйлийн арга барилын түвшинд интерацчилахыг зорьж хүснэгт байдлаар гаргасан.

Судалгааны үр дүн

Бага боловсролын сургалтын хөтөлбөр дэх нэгээс тавдугаар ангийн технологийн хичээлийн агуулгуудыг бусад бүх хичээлийн агуулгатай интеграцчилах боломжит байдлаар нь харьцуулалт хийж анги бүрд хүснэгт гаргасан. Ингэж харьцуулалт хийх нь хичээл хоорондын агуулгыг интеграцчлах боломжийг олгодог бөгөөд ингэснээр илүү цогц, үр дүнтэй заах арга барил нь багш нарт илүү үнэ цэнтэй ойлголт өгч болох юм. Жишээ болгож 1-р ангийн агуулгийг харьцуулсан хүснэгтийг орууллаа.

Хүснэгт 1. Нэгдүгээр ангийн агуулгуудад хийсэн харьцуулалт

Технологи хичээлийн агуулга	Дүрслэх урлаг	Хүн орчин	Монгол хэл	Хөгжим	Математик
1.2а. Үндсэн дүрсийг хайчлах, эвлүүлэх, өрөх аргаар бүтээх	Математик хичээлийн агуулга 1.3а. Цэг, хэрчим, тахир шугам, гурвалжин, дөрвөлжин, дугуй дүрсийг нэрлэх, эдгээр дүрсийг хоёр тэнцүү хэсэг болгон нугалах аргаар тэгш хэмтэй эсэхийг таних, биет болон хэв хэрэглэн дүрс зурах, бүтээл хийх				
1.2б. Үндсэн дүрсийг зохиомжлон наах аргаар бүтээл хийх	Дүрслэх урлаг хичээлийн агуулга 1.1г. Энгийн дүрсээс бүтсэн эд юмсыг дүрслэхдээ шулуун, долгион, нуман, тахир зураасыг хэрэглэх 1.1д. Үндсэн 5 дүрсийн нийлэмжийг эд юмсыг дүрслэхдээ ашиглах				
	Монгол хэл хичээлийн агуулга 1.1б. Сурах бичгийн эх, зурагт эх, богино хэмжээтэй хялбар эхийг уншиж агуулгыг ерөнхийд нь ойлгосноо харуулах				
	Хөгжим хичээлийн агуулга 1.1д. Төрөл бүрийн материал ашиглан хөгжмийн энгийн зэмсэг бүтээж, байгалийн дуу чимээ, амьтдад тохирох дуу авиа үүсгэж үзүүлэх				
1.2в. Үндсэн дүрсийг эвлүүлж наах аргыг техникийн загвар бүтээхэд хэрэглэх	Дүрслэх урлаг хичээлийн агуулга 1.1д. Үндсэн 5 дүрсийн нийлэмжийг эд юмсыг дүрслэхдээ ашиглах				
1.2г. Амьтны ба техникийн загвар бүтээхэд цаасыг тэнцүү хэсэг болгон нугалж хайчлах аргыг ашиглах	Хүн орчин хичээлийн агуулга 1.4г. Орон нутагтаа амьдардаг гэрийн тэжээмэл амьтдыг нэрлэж, хайрлан хамгаалах арга, ашиг шимийг жишээгээр тайлбарлах				
	Математик хичээлийн агуулга 1.3а. Цэг, хэрчим, тахир шугам, гурвалжин, дөрвөлжин, дугуй дүрсийг нэрлэх, эдгээр дүрсийг хоёр тэнцүү хэсэг болгон нугалах аргаар тэгш хэмтэй эсэхийг таних, биет болон хэв хэрэглэн дүрс зурах, бүтээл хийх				


1.2д. Цаасыг нугалах аргаар бүтээл хийх	Монгол хэл хичээлийн агуулга				
	1.1е. Зохиолын баатруудын гадаад байдлыг төсөөлж ярих				
	Хөгжим хичээлийн агуулга				
1.2е. Навч өрж наах аргаар амьтны дүрс бүтээх	1.1д. Төрөл бүрийн материал ашиглан хөгжмийн энгийн зэмсэг бүтээж, байгалийн дуу чимээ, амьтдад тохирох дуу авиа үүсгэж үзүүлэх				
	Математик хичээлийн агуулга				
	1.3а. Цэг, хэрчим, тахир шугам, гурвалжин, дөрвөлжин, дугуй дүрсийг нэрлэх, эдгээр дүрсийг хоёр тэнцүү хэсэг болгон нугалах аргаар тэгш хэмтэй эсэхийг таних, биет болон хэв хэрэглэн дүрс зурах, бүтээл хийх				
1.2ж. Баримлын шавартай ажиллах хэрэглэгдэхүүнийг таньж зориулалтыг тодорхойлох	Хүн орчин хичээлийн агуулга				
	1.3б. Ангид ургаж буй ургамлын бүтцийн хэсгүүдийг ялган таньж, нэрлэх				
	1.4г. Орон нутагтаа амьдардаг гэрийн гэжээмэл амьтдыг нэрлэж, хайрлан хамгаалах арга, ашиг шимийг жишээгээр тайлбарлах				
1.2з. Баримлын шаврыг хавтгайлах, хэвлэх аргаар хагас товгор дүрс бүтээх	Дүрслэх урлаг хичээлийн агуулга				
	1.1а. Зургийн багаж, хэрэглэгдэхүүнийг таньж хэрэглээг тодорхойлох				
	Хүн орчин хичээлийн агуулга				
1.2и. Баримлын шаврыг цувих, хэрчих, бөөрөнхийлөх, холбох, мушгих аргаар хүнсний ногоо, жимс жимсгэний загвар хийх	1.1а. Өөрийн хичээлийн хэрэглэлээ нэрлэж, үүрэг зориулалтаар нь ялган таних				
	Хөгжим хичээлийн агуулга				
	1.1д. Төрөл бүрийн материал ашиглан хөгжмийн энгийн зэмсэг бүтээж, байгалийн дуу чимээ, амьтдад тохирох дуу авиа үүсгэж үзүүлэх				
Нийт 9 агуулга	Хүн орчин хичээлийн агуулга				
	1.3б. Ангид ургаж буй ургамлын бүтцийн хэсгүүдийг ялган таньж, нэрлэх				
	1.4в. Орон нутагтаа ургадаг хүнсний ногоо болон жимс, жимсгэнийг ялган таних				
Нийт 9 агуулга	3 агуулга дээр боломжит	4 агуулга дээр боломжит	2 агуулга дээр боломжит	3 агуулга дээр боломжит	3 агуулга дээр боломжит

Нийт 6 хичээлээс 5 хичээлийн 18 агуулгатай интеграцчилах боломжит. Технологийн хичээлийн нийт 9 агуулгаас бусад хичээлтэй агуулгаараа холбогдоогүй агуулга байхгүй.

Бага боловсролын технологийн хичээлийн 1, 2, 5-р ангийн бүх агуулгууд бусад хичээлтэй агуулгаараа интеграцчилагдах боломжтой. 3-р ангийн 2 агуулга, 4-р ангийн 3 агуулга нь бусад хичээлийн агуулгатай холбогдоогүй үлдсэн. Эндээс харахад хүснэгтэд агуулгаараа холбогдсон хичээлүүдийг гадаад интеграци талаас нь сургалтыг явуулах боломжтой гэдэг нь харагдаж байна.

Технологи хичээлийн агуулгатай бусад хичээлүүдийн агуулга интеграцчилагдах боломжит хувилбарыг нэгээс тавдугаар анги хүртэл харьцуулсан байдлаар доор графикаар харууллаа.

График 1. Технологи хичээлийн агуулгатай бусад хичээлүүдийн агуулгатай интеграцчилагдах боломжит хувилбарын тоо (1-5 анги)



Бага боловсролын технологийн сургалтын хөтөлбөрт хийсэн дүн шинжилгээ нь бусад хичээлтэй интеграцчлах дараах боломжуудыг илрүүлсэн. Технологийн хичээл нь нийт 56 агуулгатай. Үүнээс 26 агуулга буюу 46% нь математикийн хичээлтэй, 20 агуулга буюу 35,7% нь хүн орчин, хүн байгаль хичээлтэй, 19 агуулга буюу 33.9% нь дүрслэх урлагийн хичээлтэй түлхүү интеграцчилагдах боломжит хувилбар харагдаж байна.

Дүгнэлт

Бага боловсролын сургалтын хөтөлбөрт дүн шинжилгээ хийх нь технологийн хичээлийг бусад хичээлүүдтэй нэгтгэх ихээхэн боломж байгааг харуулж байна. 1-5-р ангийн хичээлүүдийг дунджаар нь буюу 7 хичээл ордог гэж үзвэл 5 хичээлтэй агуулгаараа интеграцчилагдах боломжтой буюу 71.4% -ийн шууд эерэг хамаарал гэж гарсан нь технологийн хичээлийг бусад хичээлтэй агуулгаар нь интеграцчилах боломжтой буюу хичээлүүдийн агуулга арга зүйд шууд эерэг хамааралтай.

Сургалтыг уламжлалт байдлаар явуулахаас татгалзаж агуулгын хэмжээг багасгах, сурагчдын сурах ачааллыг багасгах, технологийн хичээлийг заахад тулгардаг бэрхшээлээс багасгах боломж нь бага боловсролын хичээл хоорондын холбоо хамаарлыг агуулгаар нь тэр дундаа технологийн хичээлийг бусад хичээлийн агуулгатай интеграцчилах боломжтой гэдэг нь анги бүрт агуулгаар нь харьцуулсан хүснэгт, графикууд дээрээс харагдаж байна. Орохгүй орхигдуулж байгаа технологийн хичээлийн агуулга нь бусад хичээлтэй интеграцлагдан орсноор хичээлийн чанар, хүүхдийн хөгжилд эерэг нөлөөтэй гэж үзэж байна.

Ном зүй

- Батхуяг, С., Төртогтох, Б., Цогзолмаа, Н. (2015). Боловсрол судлалын судалгааны ажлын арга техник. Улаанбаатар: Хүслийн өнгө.
- Баярмагнай, З., нар. (2018). *Бага боловсролын дүрслэх урлаг сургалтын онол арга зүй*. Улаанбаатар
- БСШУЯ. (2018). Тогтвортой хөгжлийн боловсролыг сургуулийн сургалт, сургалтыг дэмжих үйл ажиллагаанд интеграцчилах арга зүй. Улаанбаатар
- БСШУСЯ. (2019). Бага боловсролын сургалтын хөтөлбөр. Улаанбаатар
- БСШУСЯ. (2019). Дээд боловсролын нэр томъёоны монгол-англи-орос тайлбар толь. Улаанбаатар: Содпресс.
- Ичинхорлоо, Ш. (2013). Сургалтын онол хэрэглээ. Улаанбаатар.
- МУБИС-ДУТС. (2013). *Дүрслэх урлаг, Технологи, Дизайны сургалтын тулгамдсан асуудал, шийдвэрлэх арга зам. ЭШХИ-ийн эмхтгэл*. Улаанбаатар: Соёмбо принтинг.
- МУГЗ. (2020). *“Алсын хараа 2050” Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн танилцуулга*. Улаанбаатар.
- Чулуунаа, Г. (2022). Дизайн технологийн боловсролын онол арга зүйн зарим асуудал. Улаанбаатар.
- UNESCO. (2019). Монгол улсын боловсролын бодлогын тойм шинжилгээ. Улаанбаатар.
- Берулава, М.Н. (1993). Интеграция содержания образования.
- Кузьмин, В.Н. (1986). Принцип системности в теории и методологии.
- АДЪЯАМАА, Ш. (2022, 10, 26). Л.Энх-Амгалан: Сурагчдыг гэрийн даалгавраар шахаж байгаа нь үнэн, үүнийг өөрчилнө. <https://zarig.mn/11c8>

INTEGRATION OF PRIMARY EDUCATION TECHNOLOGY LESSON WITH OTHER LESSONS

Jargal.B^a
^aTeachers School, MNUE

Corresponding author: Jargal.b@msue.edu.mn 

Abstract

Our research focused on the subject content and workload issues in the primary education curriculum, and pointed out that there is a lack of coherence and integration of subjects and that there are conflicts that need to be addressed.

One possible solution to the problem was the integration of technology courses with other subjects. Thus, it was hypothesized that there is a direct positive relationship between the content of the courses and the methodology.

Using theoretical and qualitative research methods, we compared the content of all subjects in the first to fifth grades of the primary education program. As a result of the research, it has been shown that it is possible to conduct courses related to content from the perspective of external integration, or to consider technology courses in conjunction with mathematics, human environment, human nature, and visual arts from an interdisciplinary perspective.

Integrating technology with other subjects has several advantages. For example, reducing the amount of content, reducing the teaching load, rejecting traditional methods, and solving the problems faced by educational technology.

In the end, it was believed that this integrated approach would have a positive impact on the quality of lessons, on the content of technology lessons that are being left out, and on the overall development of children.

Keywords

Load, content, opportunities, quality of education, child development